

**ХЭНРИ ШВАРЦ (ярилцлага)**

**НЭРТ МОНГОЛ СУДЛААЧ ХЭНРИ ШВАРЦ:** АМЕРИКИЙН МОНГОЛЧ НАР ХУВИАРАА БОЛОН ХАМТААРАА ЧАРМАЙН АЖИЛЛАЖ, МОНГОЛ СУДЛАЛЫГ АМЕРИКИЙН ИХ СУРГУУЛИУДАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН СУДЛАГДАХУУН БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ.

Нэрт Монгол судлаач, АНУ дахь Монгол судлаачдын ахмад үеийнхний нэг, Вестэрн Вашингтоны Их Сургуульд Монгол Судлалыг үндэслэгч, доктор, профессор Хэнри Шварцтай хийсэн ярилцлага.

Бэллинхэм хот, АНУ.

Ярилцсан др. Мягмарын Саруул-Эрдэнэ (Индианагийн Их Сургууль)

**Та анх хэрхэн Монгол судлалыг сонирхох болсон юм бэ?**

Яг шууд Монголыг сонирхон судалж эхлээгүй юм аа. Дөчөөд оны сүүл, тавиад оны эхээр би Висконсины Их Сургуульд Нийгмийн Сэтгэлзүйгээр сурч байлаа. Сурч байхдаа Орчин Цагийн Хятад Хэлний хичээл авдаг байв. Дараа нь цэрэгт татагдаад тавиад оны сүүлээр эргэж Мадисонд ирснээсээ хойш Хятадын түүх, улс төрийн хичээлүүдийг ихэд сонирхон суух болсон юм. Ингэж байхдаа Хятадаас илүү цөөнхийг нь, ялангуяа Уйгур, Монгол үндэстнийг гүнзгий сонирхож эхэлсэн дээ. Докторын зэрэг хамгаалснаасаа хойш энэ хоёр үндэстний аль алианаар нь бичиж, туурвиж эхэлсэн боловч Монгол тал нь арай давамгай юм.

**Вестэрн Вашингтоны Их Сургуульд зааж буй Монгол Судлалын гол гол хичээлүүд юу вэ?**

Гол хичээлүүд гэвэл Түүх, Угсаатны зүйг нэрлэх байна. Би гурван хичээл зааж байлаа. Хоёр нь Монголын Эзэнт гүрний үе болон түнээс хойших үеийн түүх. Нөгөө нь Монгол нийгэм, соёлын тухай хичээл. Наяад оны дундуур Линда Кимбалл ирж, Төв Азийн угсаатны зүй зааж эхэлсэн бол бусад багш нар хожим Монгол болон төлөвшсөн Монголоос өмнөх овог, аймгуудын талаар заадаг байлаа. 1993 оны хамгийн сүүлчийн өдөр миний бие тэтгэвэрт гарч, харин Сибирийн хэлнүүдийн нэрт судлаач Эдди Ваяда Монголын Хөтөлбөрт маань хамрагдсанаар надаас хойш Монголтой холбоотой оюутнуудын их сонрхдог, ерөнхий хичээлүүдийг зааж байна.

**Вестэрн Вашингтоны Их Сургууль дахь Монголын Хөтөлбөрийг үндэслэгчийн хувьд хөтөлбөрөө хэрхэн эхэлсэн тухай ярьж өгөхгүй юу?**

Монголын хөтөлбөр нь албан ёсоор 1975 онд, манай сургуулийн Зүүн Ази Судлалын Төвийн дөрөв дэх үндсэн чиглэл болон нэмэгдсэн юм. Өмнө нь Хятад, Солонгос, Японы хөтөлбөр хэрэгжиж эхлээд байлаа. Өмнө нь манай багш нар, би өөрөө ч Монголтой холбоотой түүх, соёлын хичээл зааж байсан л даа.

Яг миний өөрийн гүйцэтгэсэн үүрэг хэмээн яривал, би бүр 1969 онд Вестэрн Вашингтоны Их Сургуульд анх ирснээсээ хойш л энэ талаар хөөцөлдөж эхэлсэн хүн. Миний гол зорилго бол зөвхөн Хятад, Япон төдийгүй Солонгос, Монгол судлалыг багтаасан Зүүн Ази Судлалын Төв байгуулах явдал байлаа. Өмнө нь миний хэдэн жил хичээл зааж байсан Сиэттл хот дахь Вашингтоны Их Сургуульд болсон явдлаас шалтгаалан Зүүн Ази Судлалын Төвд Монгол судлалыг хамруулан нээх нь миний хувьд нэн чухал асуудал болоод байв. Юу болсон хэмээвээс, миний хамгийн дотнын найз, мэргэжил нэгт нөхөр Николас Поппе 1951 онд тэр сургуульд ирээд маш чанартай Монгол Судлалын хөтөлбөр нээн ажиллуулсан боловч түүнийг тэтгэвэрт гарахад би болон бусдууд маань бүгд зэрэг Сиэттлийг орхин, Поппегийн үйл хэрэг төгсгөл болсон юм. Поппегийн хувьд энэ нь тун хүнд туссан тул миний бие харин яг тэр орчимд, Сиэттлээс холгүй Монгол судлалыг дахин сэргээсэн билээ.

Монгол судлал дахь оролцоо, сонирхлыг маань тэтгэн дэмжсэн бас нэгэн явдал 1973 онд болсон нь энэ жил анх удаа би Бээжин дэх Үндэстний Төв Хүрээлэнд (Жонянг минзу шүеюан) зуныг өнгөрөөв. Үүнээс хойш олон зун энд ажилласан билээ. Тэнд байх хугацаандаа би Өвөр Монгол болон Хятадын бусад Монголчууд бүхий газруудаар аялж, ном цуглуулан Вестэрн Вашингтоны Их Сургуулийн номын санд хандивлаж эхлэв. Тэр эхний жил буюу 1973 онд анх би 93 боть ном хандивлаж байсан бол үүнээс хойш 14 мянга гаруй ном өргөсөн билээ.

Дараагийн томоохон алхам 1978 бил үү, 79 онд тохиосон юм. Өвөр Монгол руу нэг

удаа аялж явахдаа би Чингэлтэй багштай уулзаж, Америк оюутнуудыг тэднийд сургах боломжийн талаар санал солилцов. Өвөр Монголын Их Сургууль бол олон нэртэй Монгол судлаач бэлтгэсэн газар билээ. Уг нь би тиймэрхүү хөтөлбөрийг Улаанбаатарт бас зохион байгуулъя хэмээн санал гаргаж байсан боловч тухайн үеийн улс төрийн байдлаас болж бүтээгүй. Бээжин албан ёсоор энэ саналыг 1981 онд баталснаас хойш би 10 жилийн турш Өвөр Монголд Монгол хэлний анхан болон дунд шатны сургалт зохион байгуулсан билээ. АНУ-ын олон их сургуулийн оюутан, судлаачид энэ сургалтад хамрагдсан.

**Таны зохион байгуулж байсан Монгол Хэлний Зуны Сургалтаас олон сайн Монголч төрөн гарсан. Тэдний зарим нь, тухайлбал Уэйн Рихтэр, Христофер Этвүд Монголоор сайн ярьдаг. Ер нь Өвөр Монголд ярианы Монгол хэл сурах хэцүү байсан уу?**

Олон арван жилийн туршид Хөххот хятаджиж, нийтийн тээвэр, дэлгүүр хоршоонд оюутнууд маань ойр зуурын хятад хэл хэрэглэхээс аргагүй болдог байсан нь үнэн. Гэвч Монгол хэл сурах маш их боломж байсан. Юуны өмнө багш нар Даваагаас Баасан хүртэл, өдөр бүр, бүтэн долоон долоо хоног эрчимтэй ажиллаж, ихийг заадаг байлаа. Дээр нь Өвөр Монголын Их Сургуульд Чингэлтэй, Чойжинжав зэрэг гарамгай Монгол судлаачид ажилладаг, Гэрэлтү зэрэг алдарт найрагчид оюутнуудтай маань ярилцах цаг зав байнга гаргадаг байв. Их сургуулиас гараад ч тэр, нэг их хол явалгүй, номын дэлгүүр зэргээр ороход Монгол хэлээрээ дадлага хийчих газар олддог байлаа.

**Яриагаа Вестэрн Вашингтоны Их Сургуулиас тэлж, АНУ-ын Монгол судлалд хандуулъя. Хамгийн ахмад Монгол эрдэмтдийн нэгийн хувьд та энэ улс дахь Монгол судлалын үүсэл, цар хүрээг базан өгүүлбэл?**

Энэ асуултад би цаг хугацаа болон орон зай гэсэн хоёр чиглэлээр хариулт өгье. Цаг хугацааны үүднээс авч үзвэл АНУ-д үнэн хэрэгтээ Дэлхийн 2-р дайнаас хойш л Монгол судлал жинхэнэ утгаараа эхэлсэн гэж хэлж болно. Мэдээж хэрэг, Монголыг хичээлийнхээ хөтөлбөрт тусгасан багш нар өмнө байсан боловч чухам 50-иад оны үеэс л хожмоо Монгол Судлалын Хөтөлбөр хэмээн нэрлэгдэж чадахуйц болсон сургалтууд зарим нэг их сургууль дээр эхэлсэн юм. Хамгийн анхны хийгээд зарим талаар бас хамгийн амжилттай хэрэгжсэн гэж болох хөтөлбөрүүдийн нэг нь Вашингтоны Их Сургууль дээр буй болсныг чухамдаа ганц хүний мэдлэг, хөдөлмөрийн үр дүн хэмээн хэлж болно. Энэ хүн бол агуу Монголч Николас Поппе. Тэрбээр олон гарамгай Монголч эрдэмтдийг бэлтгэсний дотор Жон Крюгер буй. Гэвч миний өмнө өгүүлсэнчлэн Поппегийн үүтгэсэн тэр сайхан хөтөлбөр өөрийг нь тэтгэвэрт гарахтай зэрэг унтарсан юм. Харамсалтай нь АНУ-ын эрдмийн байгууллагуудад жижиг хөтөлбөр хөрөнгө мөнгөнөөс болж мөхөх нь тийм ч ховор үзэгдэл биш ээ. Үүнээс ургуулан бодоход би бол тун азтай хүн. Намайг тэтгэвэрт гарснаас хойш манай Монгол хөтөлбөр зогсох нь байтугай урагшлан хөгжиж байна.

Энэ дээрх ажиглалтаасаа үүдэн Америкийн Монголч эрдэмтэд бидний ажиллаж буй орон зай, газарзүйн онцлогийн талаар хэдэн үг хэлье. Олон нийтийн дундах Монголчуудын талаарх мэдлэг өсч байгаа өнөө үед Монгол улс болон Монголчуудын талаарх судалгаа цар хүрээний хувьд тэлж байгаад бид их баяртай байгаа. Гэвч бид хэт үнэмшилгүй итгэл найдвараас сэргийлэх хэрэгтэй. Хойд Америк дахь Монгол судлал бол түүхэн болон газарзүйн аль ч үүднээс энэ бүсийн эрдмийн ертөнцөд захын судлагдахуун байсаар байх болно. Зүүн Азийн улсууд, Энэдхэг, Орос болон Европын олон улстай харьцуулахад АНУ нь орон зайн хувьд Монголоос асар хол. Үүнээс болж дээр дурдсан бусад улсын Монголтой харьцаж байсан шиг нэн эртний түүхэн холбоо манай хоёр улсын хооронд тогтож байсангүй. Энэ баримтаас Америкийн Монголч эрдэмтэд сургамж аван, бие тоон тайвшрах бус харин ч хувиараа болон хамтаараа чармайн ажиллаж, дурдсан бэрхшээлийг даван туулж, Монгол судлалыг Америкийн их сургуулиудад хүлээн зөвшөөрөгдсөн, тогтвортой судлагдахуун болгох шаардлагатай юм.

**Эцэст нь “Монгол Нийгэмлэг”-ийн нийт гишүүдийн өмнөөс танд манай нийгэмлэгийн Ерөнхийлөгчөөр олон жил ажиллаж, мэдлэг оюун, хүч хөдөлмөрөө зарсанд тань баярлалаа хэмээн хэлье.**

“Монгол Нийгэмлэг”-ийн Ерөнхийлөгчөөр есөн жил ажилласан маань миний

хувьд нэр хүндийн хэрэг байлаа. Өнгөрсөн дөчин таван жилийн туршид эрдмийн энэ байгууллага Монголтой холбоотой бүгдийг эрдэмтэн судлаачид болон жирийн иргэдэд түгээн хүргэж ирлээ. Энэ сарын сүүлээр намайг албаа өгснөөс хойш ч

“Монгол Нийгэмлэг”-ийн ажил мандан бадарсаар байх болно хэмээн итгэнэ.

**Abstract:** Study of the Chingis-khan's death place and the possible location of his monument in Ning-xia. Shirchin Baatar Ph.D., visiting scholar for Khitan studies, Institute of East Asian Studies, University of California Berkeley. Chingis-khan passed away in the upper stream areas of the Yellow River (*Shar murun* in Mongolian, *Huanhe* in Chinese) during the Xixia (Tangut) invasion in 1227. Even today, we still cannot identify the exact location of his death and burial. According to my research, I made a conjecture that the location of his death is somewhere near Qingtongxia, which is a town in the Ning-xia Province, a former Xixia territory where Yellow River passes behind. The reason behind my hypothesis is that a pyramid-shaped 108-stupa (dagoba) monument was built in the Jiakou hillside of Qingtongxia. The design that these stupas exhibit is very similar to that of the Khidan and Yuan periods. Furthermore, I suspect that the Chingis-khan's family members, including his wife Esui and his grandsons who ruled the Yuan Empire, built the 108 stupas to serve as a memorial to Chingis-khan's death place.